

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

---

***Гүйцэтгэлийн аудитын тайлан***

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц



**ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУД  
ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛЭЭР 2358,4 СЯА  
ТӨГРӨГИЙН ӨРТЭЙ ГАРАХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.**

Өлгий

## АГУУЛГА

<p><b>Тайланг бэлтгэсэн:</b></p> <p><b>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар</b></p> <p><b>Дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Хуанган</b></p> <p><b>Аудитын менежер</b> Х.Женисбек</p> <p><b>Аудитын баг:</b></p> <p><b>Ахлах аудитор</b> М.Айнур</p> <p><b>Аудитор</b> Х.Еркебулан У.Ербол</p> <p><b>2018 оны 11 дүгээр сар</b></p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 94159291 дугаарын утсаар харилцана уу</p> <p><b>ХАЯГ:</b></p> <p>Аймгийн ЗДТГазрын байр 1 дүгээр давхар 108 тоот өрөө</p>	Товчилсон үгийн тайлбар	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
	<p><b>Бүлэг 1 Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүй байна.</b></p> <p>1. Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг нэмэгдүүлэх зарим нөөц боломжийг зөв тооцоогүй байна. 7</p> <p>2. Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг төлөвлөхдөө орон тооны хязгаарыг баримтлаагүй, 129,5 орон тоог илүү баталж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бодитой тооцоогүй байна. 10</p> <p>3. Аймгийн 2018 оны нэгдсэн төсвийн алдагдал 16407,9 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. 15</p>	
	<p><b>Бүлэг 2 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн эхний 9 сарын орлогын төлөвлөгөө 1171,8 сая төгрөгөөр тасарсан байна.</b></p> <p>1. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр орон нутгийн суурь орлогын төлөвлөгөө 108,7 хувиар биелэгдэх боломжтой байна. 16</p> <p>2. Төсөвт болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудаас төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж байхгүй байна. 21</p>	
	<p><b>Бүлэг 3 Орон нутгийн төсөвт байгууллагууд нийтдээ 2358,4 сая төгрөгийн өртэй гарах төлөвтэй байна.</b></p> <p>1. Орон нутгийн төсөвт байгууллагууд 2018 оны эцэст хүлээгдэж буй гүйцэтгэлээр батлагдсан төсвөөс 2358,4 сая төгрөгийн илүү зарлага гаргаж, өр үүсгэх болзошгүй байна. 23</p> <p>2. 3 дугаар улирлын дүнгээр ОНХ сан, ОНХО-ын 15 төсөл арга хэмжээний тендер зарлагдаагүй байна. 27</p>	
	<p><b>Бүлэг 4 ТЕЗ-ийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохих журмаар тайлагнаагүй байна.</b></p> <p>1. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг зохих журмаар баталсан байна. 32</p> <p>2. ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг зохих журмын дагуу дүгнэж тайлагнаагүй байна. 33</p> <p>3. Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлсэн байна. 37</p>	
	Дүгнэлт.....	39
	Зөвлөмж: .....	40
	<p><b>Холбогдох байгууллагын санал:</b> Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал .....</p>	
	<p><b>Саналд өгсөн тайлбар .....</b></p>	

## Товчилсон үгийн тайлбар

<b>ҮАГ</b>	Үндэсний Аудитын газар
<b>ТЭЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
<b>ТЗШ</b>	Тусгай зориулалтын шилжүүлэг
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ОН</b>	Орон нутаг
<b>ААН</b>	Аж ахуйн нэгж
<b>ҮГ</b>	Үйлдвэрийн газар
<b>БСШУСС</b>	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайды
<b>ХХААХҮС</b>	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайд
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

### Аудитын зорилт

Төсвийн байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын А/06 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-ад хийх аудитаар аймгийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад аудит хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах санал, зөвлөмж өгөх, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэрээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх
- 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх
- ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх

### Хамарсан хүрээ

Энэхүү аудитад аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, эхний 9 сарын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшин, хэрэгжилттэй холбоотой тайлан, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалыг хамруулав.

### Үндсэн мэдээлэл:

Сангийн Яамнаас тус аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 6808,9 сая төгрөгөөр, суурь зарлагыг 23216,8 сая төгрөгөөр хянаж, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 16407,9 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна. ОНХСангаас олгох орлогын шилжүүлэгийг 4940,7 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Тусгай зориулалтын шилжүүлэгийн нийт төсөв 47750,3 сая төгрөгөөр батлагдасны 47750,3 сая төгрөгийг улсын төсвөөс, тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагуудын өөрийн орлогоос 48,3 сая төгрөг оруулахаар төлөвлөжээ. Аймгийн төсвийн нийт хэмжээ 75956,1 сая төгрөг байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 сарын 25-ны хуралдаанаар аймгийн нийт төсвийг 76460,0 сая төгрөгөөр баталжээ. Орон нутгийн суурь орлогыг 7312,8 сая төгрөгөөр,

суурь зарлагыг 23720,7 сая төгрөгөөр, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 16407,9 сая төгрөгөөр баталжээ. ОНХСангийн орлогын шилжүүлэгийн хэмжээг 4940,7 сая төгрөгөөр баталсан байна. ТЗШ-ийн нийт төсөв 47750,3 сая төгрөг байна.

Сумуудын ИТХ-аас төсвийн зарлагыг 589,5 сая төгрөгөөр нэмж баталсанаас сумын төсвийн орлогыг 94,6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 494,9 сая төгрөг бүрдүүлэхээр тусгасан байна.

Аймгийн 2018 оны нэгтгэсэн нийт төсөв 77049,5 сая төгрөг ба 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хийгдсэн төсвийн тодотголоор 78661,2 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

### **Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудад ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэх, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ, аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### **Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.Үүнд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

### **Аудитын багийн бүрэлдэхүүн**

Аудитыг ахлах аудитор М.Айнур ахалж, аудитор Х.Еркебулан, У.Ербол нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг төлөвлөгөө, хөтөлбөрийн хуваарийн дагуу хэрэгжүүлж, аудитын тайланг бэлтгэв.Аудитын тайлангийн хавсралт судалгаа мэдээнүүдийг тайланд хавсаргасан болно.

## Бүлэг 1

Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн орлого,  
зарлагыг бодитой төлөвлөөгүй байна.

### Оршил

Сангийн яамнаас 2018 оны төсвийн төсөл боловсруулахтай холбоотой “2018 оны төсвийн зарлагын төсөл боловсруулах, хянахад баримтлах удирдамж”-ийг баталж, аймгийн Төсвийн ерөнхий захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагын 2018 оны төслийг боловсруулах, хянахад дараах зарчмыг баримтлахаар удирдамжид тусгажээ. Үүнд:

1. Засгийн газрын 2017 оны 188 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 оны төсвийн хязгаарыг баримтлах, хэтрүүлэхгүй байх.

2. Зарлага бууруулах, өсөлтийг хязгаарлах чиглэлээр ОУВС-тай байгуулсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх.

3. Төсвийн үр ашгийг сайжруулах, хэмнэлтийг горимд шилжүүлэхтэй холбоотой Улсын их хурлын 2014 оны 70, 2015 оны 108, 2016 оны 47, 2017 оны 29 дүгээр тогтоол, Засгийн газрын 2014 оны 147, 2015 оны 184 тогтоолыг мөрдлөг болгох.

4. Бүтцийн өөрчлөлт, бусад шийдвэрээр орон тоо, урсгал зардал нэмэгдүүлэхгүй байх.

5. 2017 онд хэрэгжиж дууссан болон тухайн онд хэрэгжсэн нэг удаагийн шинжтэй хөтөлбөр, арга хэмжээний зардлыг бууруулж тооцох, харин үргэлжилж буй хөтөлбөр, арга хэмжээнд нэмэлт, орох тохиолдолд батлагдсан төсвийн хязгаарт багтаан зохицуулалт хийх зарчмыг баримтлах.

6. Төсвийн хязгаар батлагдсанаас хойш үүссэн нөхцөл байдлын улмаас төсвийн хязгаарт зохицуулалт хийх боломжгүй бөгөөд шинээр эсвэл нэмэлт өөрчлөлт хийхээр санал болгож буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал зардлыг хянаж, эрх бүхий дээд шатны байгууллагад танилцуулж, чиглэл авсны үндсэн дээр тусгах эсэхийг шийдвэрлэх.

Аливаа хөтөлбөр, арга хэмжээний урсгал зардлыг тооцохдоо баримтлах чиглэл, норм, норматив болон аргачлалыг энэхүү удирдамжид тодорхой тусгаж ирүүлсэн байна.

Санхүү, төрийн сангийн хэлтсээс аймгийн 2018 оны төсвийн төслийг боловсруулсан зарчим, баримталсан чиглэл болон Орон нутгийн төсвийн орлогын бүрдэлтийг сайжруулах чиглэлээр ирэх онд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг төсвийг захирагч нарт зөвлөмж болгожээ. Үүнд:

1/Татварын бүртгэлийг сайжруулах, нийгмийн даатгал болон татварын албаны хооронд мэдээлэл зөрүүтэй байгааг нягталж, татварт хамрагдаагүй хэсгийг татварт хамруулах.

2/ Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулж байгаа хөрөнгийн үнэлгээ хэт бага байгааг бусад үнэлгээтэй харьцуулах замаар нэмэгдүүлэх.

3/ Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнаас хадгаламж эзэмшигчдийн мэдээллийг тогтмол авч орлого төвлөрүүлэлтэд анхаарах.

4/ Төсвийн захирагч нар Төсвийн тухай хуульд заасан эрх үүргээ хэрэгжүүлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлж батлагдсан орон тоо, цалингийн сандаа багтааж үйл ажиллагаа явуулах, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоол, Засгийн газраас өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх замаар цалингийн ашгийн татварыг сар сардаа бүрэн төвлөрүүлж байх.

5/ Орон нутгийн төсвийн орлогод тооцоо судалгаагүй, бодитой бус орлого төлөвлөхгүй байх.

6/ Төсөвт байгууллагууд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж ИТХ-ын хуралдаанаар батлуулан хэрэгжүүлэх.

**1.Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүй байна.**

**1.2. Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг нэмэгдүүлэх зарим нөөц боломжийг зөв тооцоогүй байна.**

Сангийн яам тус аймгийн 2018 оны суурь орлогыг 6808,9 сая төгрөгөөр, суурь зарлагыг 23216,8 сая төгрөгөөр хянаж, төсвийн үндсэн тэнцэл 16407,9 сая төгрөгийн алдагдлыг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэгт 4940,7 сая төгрөг хуваарилсан байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтад 3983,4 сая төгрөгийг суурь зарлагад оруулж баталжээ.

Тусгай зориулалтын шилжүүлгийн 2018 оны төсөвт нийтдээ 47798,6 сая төгрөг хуваарилсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар аймгийн 2018 оны төсвийг хэлэлцэж, “Аймгийн 2018 оны төсөв батлах тухай” 26 дугаар тогтоол гаргасан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал 2018 оны төсвийг хэлэлцэж батлахдаа Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг 8.5 дахь хэсгийн 8.5.2-т “аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах” гэсэн заалтыг баримтлаагүй байна.



Төсвийн орлогын төлөвлөлтийн талаар:

*Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн тооцоогүй, доод хэмжээг баримталсан байна.*

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаас 2018 оны орон нутгийн төсвийн нийт орлогыг 76460,0 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд урсгал орлого 7312,8 сая төгрөг, тусламжийн орлого нийтдээ 69147,2 сая төгрөг байна.

Тусламжийн орлогын 16407,9 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 47750,3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 48,3 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 4940,7 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр бүрдүүлэхээр тусгажээ.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал орон нутгийн нийт урсгал орлогыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн хэмжээнээс 503,9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 7312,8 сая төгрөгөөр баталж, аймгийн төсөвт орох орлогыг 6303,2 сая төгрөгөөр, сумын төсөвт орох орлогын хэмжээг 1009,6 сая төгрөгөөр тогтоосон байна.

Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 503,9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бусад орлогыг Сангийн яамнаас хянаж ирүүлсэн хэмжээнд баталжээ.

Аймгийн төсөвт орох нийт урсгал орлогын 93,5 хувийг буюу 5892,3 сая төгрөгийг татварын орлогоос, 6,5 хувийг буюу 410,9 сая төгрөгийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөг 2017 оны төлөвлөгөөтэй харьцуулахад нийт дүнгээр 490,0 сая төгрөгөөр буюу 7,2 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Үзүүлэлт	Хүснэгт №1		2018 оны орлогын төлөвлөгөө	сая төгрөг	
	2017 оны орлогын			Зөрүү	
	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	мөнгөн дүнгээр	хувиар
<b>Нийт орлого</b>	<b>6822,8</b>	<b>8279,4</b>	<b>7312,8</b>	<b>490,0</b>	<b>7,2%</b>
Татварын орлого	6233,2	7575,6	6881,4	648,2	10,4%
Татварын бус орлого	589,5	703,8	431,4	-158,1	-26,8%

Эх сурвалж: Аймгийн 2017, 2018 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн суурь орлого 2017 онд 8279,4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан ба 2018 оны орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 966,6 сая төгрөгөөр их дүнтэй байна.



Аймгийн Татварын хэлтсээс гаргаж ирүүлсэн 2018 оны орон нутгийн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл 7887,4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарах төлөвтэй байгаа ба төлөвлөгөө 574,6 сая төгрөгөөр буюу 7,8 хувиар давж биелэгдэх боломжтой гэж үзсэн байна.

Тус аудитын газраас аймгийн 2018 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн суурь орлогыг нэмэгдүүлэх дараах саналуудыг боловсруулж аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна. Үүнд:

Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 30 хувиар буюу 75,0 сая төгрөгөөр, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулж, үнэлгээг зах зээлийн үнэлгээнд ойртуулж үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 50,0 сая төгрөгөөр, хүүгийн орлогыг 300,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2018 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр 425,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэж үзсэн.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал аймаг дахь Төрийн аудитын газраас орон нутгийн төсвийн суурь орлогыг нэмэгдүүлэх дээрх саналуудыг төсөв хэлэлцэж батлахдаа харгалзаж үзээгүй байна.

Сумуудын ИТХ-аас 2018 оны сумын төсвийг хэлэлцэж батлахдаа 4 сум урсгал орлогыг 94,9 сая төгрөгөөр, зарим сум Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хэмжээгээр орлогыг 585,5 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хуралдсан ээлжит хуралдааны 37 дугаар тогтоолоор Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны “Аймгийн 2018 оны төсөв батлах тухай” 26 дугаар тогтоолоор баталсан аймгийн төсөвт орох цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 500,0 сая төгрөгөөр бууруулж, хөрөнгийн орлогыг тэр хэмжээгээр нэмэгдүүлж баталсан байна.

Тус аймгийн 2018 оны нэгтгэсэн төсвөөр орон нутгийн төсвийн суурь орлого 9884,9 сая төгрөг болж анх баталснаас 2572,1 сая төгрөгөөр, Аймгийн төсвийн нийт орлого ба тусламжийн хэмжээ 78661,2 сая төгрөг болж анх баталснаас 2201,2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг төлөвлөхдөө орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн тооцоогүй, доод хэмжээг баримталсан байна. Энэ нь орон нутгийн орлого нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна.

Төсвийн зарлагын төлөвлөлтийн талаар:

Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг төлөвлөхдөө орон тооны хязгаарыг баримтлаагүй, 129,5 орон тоог илүү баталж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бодитой тооцоогүй байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2018 оны орон нутгийн төсвийн нийт зарлагыг 76460,0 сая төгрөгөөр баталж, суурь зарлагыг Сангийн яамны хянасан хэмжээнээс 503,9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнээс орон нутгийн суурь зарлага 23720,7 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 47798,6 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 4940,7 сая төгрөг байна.

Төсвийн зарлагын санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 7312,8 сая төгрөгийг орон нутгийн орлогоос, 16407,9 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээс, 47750,3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 48,3 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 4940,7 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт №2

/сая

төгрөгөөр/

Үзүүлэлт	2017 оны төсөв	Сангийн яам хянасан 2018 оны төсөв	Аймгийн ИТХ-аас баталсан 2018 оны төсөв	Өсөлт, бууралт	Өсөлт, бууралт
<b>Нийт зарлага</b>	<b>72574.8</b>	<b>75956.1</b>	<b>76460.0</b>	<b>3885.2</b>	<b>503.9</b>
Бараа, үйлчилгээний зардал	53130.8	49550.3	50051.6	-3079.2	501.3
Татаас ба урсгал шилжүүлэг	17357.3	17571.7	17574.3	217.0	2.6
Хөрөнгө оруулалтын зардал	2086.7	8834.1	8834.1	6747.4	0.0

Эх сурвалж: Аймгийн 2017, 2018 оны батлагдсан төсөв

2018 оны төсвийн зарлагын төлөвлөгөөг өмнөх оны тодотгосон төсөвтэй харьцуулахад нийт дүнгээр 3885,2 мянган төгрөгөөр өссөн бөгөөд бараа, ажил үйлчилгээний зардал дүнгээрээ 3079,2 сая төгрөгөөр буурч, татаас ба урсгал шилжүүлэг 217,0 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардал 6747,4 сая төгрөгөөр нэмэгджээ.

2018 оны төсвийн зарлагын бүтцийг авч үзвэл нийт төсвийн 65.4 хувийг бараа үйлчилгээний зардал, 23,0 хувийг татаас ба урсгал шилжүүлэг, 11,6 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

**Орон тоо:** Сангийн яам аймгийн орон нутгийн төсвийн байгууллагуудын орон тоог 562 хүнээр, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын орон тоог 3852 хүнээр нийт 4414 орон тоо ажиллахаар орон тооны хязгаарыг хянаж ирүүлжээ.

Аймгийн ИТХ-аас орон нутгийн төсөвт байгууллагуудад 575, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагад 3968,5 нийт 4543,5 орон тоо ажиллахаар баталсан байна. Орон нутгийн төсөвт байгууллагуудад 13, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 116,5, бүгд 129,5 орон тоо Сангийн яамны хянасан хязгаараас илүү байна.

**Орон нутгийн төсвийн суурь зарлагын төсөв:** Орон нутгийн төсвийн суурь зарлагын 2018 оны төсөвт 28661,4 сая төгрөг батлагдаж, өмнөх онтой харьцуулахад нийт дүнгээр 5158,8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №3

/сая

төгрөгөөр/

Зарлагын нэр	2017 оны төсөв	Сангийн яам хянасан 2018 оны төсөв	Аймгийн ИТХ-аас баталсан 2018 оны төсөв	Өсөлт, бууралт	Өсөлт, бууралт
<b>Нийт зарлага</b>	<b>23502.6</b>	<b>28157.5</b>	<b>28661.4</b>	<b>5158.8</b>	<b>503.9</b>
Бараа, үйлчилгээний зардал	10086.9	7067.4	7568.7	-2518.2	501.3
Татаас ба урсгал шилжүүлэг	11371.7	12256	12258.6	886.9	2.6
Хөрөнгө оруулалтын зардал	2044.0	8834.1	8834.1	6790.1	0

Эх сурвалж: Аймгийн 2017, 2018 оны батлагдсан төсөв

Орон нутгийн төсвийн суурь зарлагын тайлант оны төсвийн 26,4 хувийг бараа үйлчилгээний зардал, 42,8 хувийг татаас ба урсгал шилжүүлэг, 30,8 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

Хүснэгт № 4

/сая төгрөгөөр/

№	Салбарын нэр	2017 оны төсөв	Сангийн яам хянасан 2018 оны төсөв	Аймгийн ИТХ-аас баталсан 2018 оны төсөв	Зөрүү
1	Аймгийн ИТХурал	367.0	129.2	338.4	209.2
2	Сумын ИТХурал	673.5	585.9	615.2	29.3
3	Аймгийн ЗДТГазар	1,679.7	1,275.5	1,282.5	7.0
4	Сумын ЗДТГазар	4,987.9	3,911.1	4,046.3	135.2
5	Хот тохижуулах газар	210.7	183.7	191.7	8.0
6	Орон нутгийн хэвлэл, мэдээллийн алба	184.6	182.8	182.8	0.0

7	Санхүүгийн хяналт, аудитын алба	103.9	89.1	102.1	13.0
8	Байгаль орчныг хамгаалах газар	459.5	430.5	448.4	17.9
9	Ойн анги	66.5	38.8	67.8	29.0
10	Орон нутгийн өмчийн газар	124.5	81.1	106.1	25.0
11	Аймгийн Засаг дарга Ерөнхий данс	375.0	358.8	408.8	50.0
12	Асрамжийн газар	89.1	87.5	89.2	1.7
13	Халамжийн сан	10,612.1	11,967.9	11,917.9	-50.0
14	Насан туршын боловсролын төв			30.0	30.0
15	Орон нутгийн хөрөнгө оруулалт	416.3	3,893.4	3,893.4	0.0
16	ОНХСангийн хөрөнгө оруулалт	1,670.4	4,940.7	4,940.7	0.0
17	Сум хөгжүүлэх сан	1,481.9			
	<b>Нийт дүн</b>	<b>23,502.6</b>	<b>28,156.0</b>	<b>28,661.3</b>	<b>503.9</b>

Эх сурвалж: Аймгийн 2017, 2018 оны батлагдсан төсөв

Аймгийн ИТХ-аас Аймгийн ИТХурал, Сумын ИТХурал, Аймгийн ЗДТГазар, Сумын ЗДТГазар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Байгаль орчныг хамгаалах газар, Ойн анги, Аймгийн Засаг дарга Ерөнхий данс, Орон нутгийн өмчийн газрын төсвийг 7,0-209,2 мянган төгрөгөөр буюу нийтдээ 503,9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ.

*Дээрх байгууллагуудын 2018 оны төсвийн зарлагыг төлөвлөхдөө орон тооны хязгаарыг баримтлаагүй, илүү орон тооны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бодитой тооцоогүй байна.*

Өмнөх онтой харьцуулахад Халамжийн сан, Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХСангийн хөрөнгө оруулалтын төсөв нэмэгдэж, бусад байгууллагын төсөв буурсан байна.

Насан туршын боловсролын төв нь өмнөх онд тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн багцад 33.9 сая төгрөгийн төсөвтэй байсныг 2018 онд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 30,0 сая төгрөгийн төсөв хуваарилж, аймгийн ИТХ-ын тогтоолын хавсралтад оруулжээ.

Тус төвийн 2018 оны төсвийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр гэсэн зардлын ангиллаар тусгаж өмнөх оноос 3,9 сая төгрөгөөр үндэслэлгүй бууруулан баталснаар хэвийн үйл ажиллагаа явуулах боломж алдагдсан байна.

Аймгийн ИТХ-д 4, Санхүүгийн хяналт, аудитын албад 1, Ойн ангид 4, Орон нутгийн өмчийн газарт 4, Сумын ЗДТГазар 2,5, бүгд 13 орон тоог Сангийн яамнаас хянасан орон тооны хязгаараас илүү баталсан байна. Насан туршын боловсролын төвийн 3 орон тоог төсөвт тусгаж батлаагүй байна.

Сумуудын ИТХ-аас 2018 оны сумын төсвийг хэлэлцэж батлахдаа Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хэмжээгээр төсвийн зарлагыг 589,5 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан. Аймаг, сумын ИТХ-аас орон нутгийн 2017 оны

төсвийн давсан орлогын үлдэгдлийг хуваарилж, төсвийн зарлагыг нэмэгдүүлсэн байна.

Тус аймгийн 2018 оны нэгтгэсэн төсвөөр Аймгийн төсвийн нийт зарлага 78661,2 сая төгрөг болж анх баталснаас 2201,2 сая төгрөгөөр нэмэгджээ.

**Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөв:** Орон нутгийн хөрөнгө оруулалтад өмнөх онд 416,0 сая төгрөг төлөвлөгдөж байсан ба Орон нутгийн хөрөнгө оруулалтын дэмжлэгт 2018 онд улсын төсвөөс анх удаа 3893,4 сая төгрөг хуваарилжээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтад хуваарилсан хөрөнгийн 70,0 хувийг буюу 2725,4 сая төгрөгийг Аймгийн Орон нутгийн төсөвт, 30,0 хувийг буюу 1168,0 сая төгрөгийг сумын Орон нутгийн төсөвт хуваарилсан байна.

**Орон нутгийн хөгжлийн сангийн төсөв:** Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгээр санхүүжих хөрөнгө оруулалтад өмнөх онд 1654,4 сая төгрөг хуваарилагдсан бол 2018 онд 4940,7 сая төгрөг батлагдаж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос 3286,3 сая төгрөгөөр буюу 2,0 дахин нэмэгдсэн байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгийн 50,4 хувийг буюу 2488,9 сая төгрөгийг сумын Орон нутгийн хөгжлийн санд, 49,6 хувийг буюу 2451,8 сая төгрөгийг Аймгийн Орон нутгийн хөгжлийн санд тус тус хуваарилжээ.

**Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв:** Тусгай зориулалтын шилжүүлгийн 2018 оны төсөвт 47798,6 сая төгрөг батлагдаж, өмнөх онтой харьцуулахад нийт дүнгээр 1273,6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4

/сая

төгрөгөөр/

Зарлагын нэр	2017 оны төсөв	Сангийн яам хянасан 2018 оны төсөв	Аймгийн ИТХ-аас баталсан 2018 оны төсөв	Өсөлт, бууралт	Өсөлт, бууралт
<b>Нийт зарлага</b>	<b>49,072.2</b>	<b>47,798.6</b>	<b>47,798.6</b>	<b>-1,273.6</b>	<b>0.0</b>
Бараа, үйлчилгээний зардал	43,089.8	42,482.9	42482.9	-606.9	0.0
Татаас ба урсгал шилжүүлэг	5982.4	5315.7	5315.7	-666.7	0.0
Хөрөнгө оруулалтын зардал					

Эх сурвалж: Аймгийн 2017, 2018 оны батлагдсан төсөв

Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн 88,9 хувийг бараа үйлчилгээний зардал, 11,1 хувийг татаас ба урсгал шилжүүлэг эзэлж байна.

Багш нарт 5 жил тутам олгох тэтгэмжид 2017 онд 2441,0 сая төгрөг, өндөр насны тэтгэвэр гарсан ажилтнуудад олгох тэтгэмжид 915,0 сая төгрөг төлөвлөгдөж 2018 онд 5 жилийн тэтгэмжид 611,0 сая төгрөг, өндөр насны тэтгэвэр гарах ажилтнуудад олгох тэтгэмжид 425,0 сая төгрөг төлөвлөгдөж, тэтгэмжийн хэмжээ буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв нийт дүнгээр буурахад нөлөөлсөн байна.

Энэ нь өнгөрсөн онд 2013 онд 5 жилийн тэтгэмж авсан багш нарын хоёр дахь циклийн үе таарсантай холбоотой байна.

Хүснэгт № 5		/сая төгрөгөөр/			
№	Салбарын нэр	2017 оны төсөв	Сангийн яам хянасан 2018 оны төсөв	Аймгийн ИТХ-аас баталсан 2018 оны төсөв	Зөрүү
1	Ерөнхий боловсрол	32,995.7	30,911.3	30,911.3	0.0
2	Сургуулийн өмнөх боловсрол	9,403.9	9,801.7	9,801.7	0.0
3	Соёл үйлчилгээ	1,951.2	1,940.4	1,940.4	0.0
4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	3,965.8	4,237.3	4,237.3	0.0
5	Газрын харилцаа кадастрын үйлчилгээ	224.4	346.7	346.7	0.0
6	Хүүхэд гэр бүл хүүхэд хамгааллын үйлчилгээ	101.4	124.8	124.8	0.0
7	Биеийн тамир спортын газар	429.8	436.4	436.4	0.0
	<b>Нийт дүн</b>	<b>49,072.2</b>	<b>47,798.6</b>	<b>47,798.6</b>	<b>0.0</b>

Эх сурвалж: Аймгийн 2017, 2018 оны батлагдсан төсөв

Тусгай зориулалтын шилжүүлгийн нийт төсвийн 64.7 хувийг ерөнхий боловсролын, 20,5 хувийг сургуулийн өмнөх боловсролын, 4,1 хувийг соёлын салбарын, 8,9 хувийг эрүүл мэндийн салбарын, 1,9 хувийг бусад салбарын төсөв эзэлж байна.

Тус аудитын газраас өнгөрсөн онд аймгийн 2018 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн зардлыг хямдруулах, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх дараах саналуудыг боловсруулж аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.Үүнд:

1. 2018 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хуваарилсан хөрөнгийг техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн зэрэг “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3-д заасан шаардлагыг хангасан орон нутагт чухал шаардлагатай, тулгамдсан, үр ашигтай төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлан зарцуулах;

2. УИХ-ын 2017 оны 29 тоот тогтоолын 5, 6 дахь заалтуудыг үндэслэн төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахгүй байх, 2017-2019 онд өндөр насны тэтгэвэрт гарах, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоонд нөхөн томилгоо хийхгүйгээр ажил үүргийн хуваарийг оновчтой шинэчлэн тогтоох замаар ачааллыг нягтруулан ажиллах.
3. Сангийн яамнаас хянаж ирүүлсэн орон тооны хязгаарт багтааж бүтэц орон тоог баталж, баталсан хязгаараас илүү ажиллуулж байгаа орон тооны асуудлыг цэгцлэх.
4. 2018 оны төсөвт бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг Сангийн яамнаас баталсан хязгаараас нэмэгдүүлэхгүй батлах.
5. Орон нутгийн орлого нэмэгдүүлэх саналын үндсэн дээр нэмэгдэх хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн урсгал зардалд зарцуулахгүй байх, хөрөнгө оруулалтын чиглэлээр үр ашигтай төсөл арга хэмжээнд хуваарилж зарцуулах.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга аймаг дахь Төрийн аудитын газраас хүргүүлсэн дээрх саналуудыг төсөв хэлэлцэж батлахдаа харгалзаж үзээгүй байгаа нь энэ аудитаар харагдаж байна.

### **1.3. Аймгийн 2018 оны нэгдсэн төсвийн алдагдал 16407,9 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.**

Сангийн яамнаас тус аймгийн 2018 оны суурь орлогыг 6808,9 сая төгрөгөөр, суурь зарлагыг 23216,8 сая төгрөгөөр хянаж, төсвийн үндсэн тэнцэл 16407,9 сая төгрөгийн алдагдлыг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ИТХ-аас 2018 оны төсвийг хэлэлцэж батлахдаа орон нутгийн суурь орлогыг 7312,8 сая төгрөгөөр, суурь зарлагыг 232720,7 сая төгрөгөөр баталж, аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 16407,9 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

## **Бүлэг 2**

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн эхний 9 сарын орлогын төлөвлөгөө 1171,8 сая төгрөгөөр тасарсан байна.



**2. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн эхний 9 сарын орлогын төлөвлөгөө 1171,8 сая төгрөгөөр тасарсан байна.**

2.1.1 Орон нутгийн төсөвт байгууллагууд 2018 оны эцэст хүлээгдэж буй гүйцэтгэлээр батлагдсан төсвөөс 2358,4 сая төгрөгийн илүү зарлага гаргаж, өр үүсгэх болзошгүй байна.

2018 оны орон нутгийн суурь орлогын эхний 9 сарын гүйцэтгэлээр нийтдээ 5611.7 сая төгрөгийн орлого орж, 127,1 сая төгрөгөөр буюу 102 хувиар биелэгдсэн байна.

Хүснэгт №01

/ сая төгрөгөөр/

1	2018 оны 9 сарын гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/		
	ᠶᠡᠨᠡᠨᠢᠨᠢ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүнгээр
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>5 484,6</b>	<b>5 611,70</b>	<b>127,10</b>
	<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>5 484,6</b>	<b>5 609,50</b>	<b>124,90</b>
	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>5 161,1</b>	<b>4 548,5</b>	<b>- 612,60</b>
	<b>Орлогын албан татвар</b>	<b>4 190,2</b>	<b>3 306,40</b>	<b>- 883,80</b>
	<b>ХАОАТатвар</b>	<b>4 190,2</b>	<b>3 306,4</b>	<b>- 883,80</b>
110001	ᠣᠶᠡᠨᠡᠨᠢᠨᠢ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ	4 510,4	2 962,90	- 1 547,50
110002	Үйл ажиллагааны орлого	187,5	355,40	167,90
	хөрөнгийн орлого	225,0	2,00	
110004	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	52,5	-	- 52,50
110005	ШУУЗУБТАЗБүтээх орлогын татвар	2,3	-	- 2,30
110008	Шууд бус орлого	-	0,50	0,50
110101	ХХОАТатварын буцаан олголт	(787,5)	- 14,40	773,10
	<b>Өмчийн татвар</b>	<b>448,2</b>	<b>555,0</b>	<b>106,80</b>
113001	ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ	188,6	260,00	71,40
113002	ᠠᠲᠤᠨᠢ ᠠᠶᠡᠭᠡᠨᠢ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ	36,0	10,40	- 25,60
113003	ᠠᠲᠤᠨᠢ ᠠᠶᠡᠭᠡᠨᠢ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ	223,6	284,60	61,00
	<b>Бусад татвар</b>	<b>336,7</b>	<b>302,30</b>	<b>- 34,40</b>
118001	ᠣᠶᠡᠨᠡᠨᠢᠨᠢ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ	228,7	197,40	- 31,30
118101	ᠠᠶᠤᠨᠢ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ	77,2	64,80	- 12,40
118006	ᠣᠶᠡᠨᠡᠨᠢᠨᠢ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ	28,5	4,60	- 23,90
118009	Хог хягдалын үйлчилгээний хураамж	2,3	0,30	- 2,00
118011	бусад татвар	-	35,20	35,20
	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>186,0</b>	<b>384,80</b>	<b>198,80</b>
118203	Ус, рашаан ашигласны төлбөр	7,5	10,40	2,90
118201	ᠶᠡᠨᠡᠨᠢᠨᠢ хэрэглээний ᠶᠡᠨᠡᠨᠢ, ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠠᠶᠡᠭᠡᠨᠢ	33,8	19,70	- 14,10
118204	Байгалийн ургамлын НАТөлбөр	-	2,40	2,40
118202	ᠠᠭᠨᠠᠭᠤᠨᠢ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ ᠲᠡᠭᠦᠯᠡᠭᠡ, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	144,7	352,30	207,60

<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>323,5</b>	<b>1 061,00</b>	<b>737,50</b>
120001	Хувьцааны ноогдол ашиг			-
120002	Хүүгийн орлого	165,00	708,90	<b>543,90</b>
120003	Торгуулийн орлого	-	253,30	<b>253,30</b>
	Төсөвт газрын өөрийн орлого	38,50	-	- <b>38,50</b>
120009	Бусад нэр заагдаагүй орлого	120,00	98,80	- <b>21,20</b>
<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>		<b>-</b>	<b>2,2</b>	<b>2,20</b>
	Төрийн болон орон нутгийн ХБ орлого		2,20	

Эх сурвалж: Орон нутгийн орлогын ерөнхий дансны хуулга

Орон нутгийн татварын орлого 612,5 сая төгрөгөөр буюу 11,9 хувиар тасалдаж, татварын бус орлого 737,4 сая төгрөгөөр буюу 327 хувиар давж биелэгджээ.

Татварын орлого дотор өмчийн татвар 106,9 сая төгрөгөөр буюу 23,8 хувиар, байгалийн нөөц ашигласны төлбөр 198,8 сая төгрөгөөр буюу 106,9 хувиар давж, ХХОАТ болон бусад татвар 34,8-883,8 сая төгрөгөөр буюу 10,2-21,1 хувиар тасарсан байна.

Татварын бус орлогоос хадгаламжийн хүүгийн орлого, торгуулийн орлого 797,2 сая төгрөгөөр буюу 5,8 дахин давж биелэгдэж байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдын дүнгээр үзэхэд дараах байдалтай байна.Үүнд:

Хүснэгт №02

№	Сумын нэр	<b>/сая төгрөгөөр/</b>			
		<b>2018 он</b>			
		Төлөвлөгөө	9 сарын 30-ны гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Алтай	34,3	79,0	44,7	230,5
2	Алтанцөгц	10,7	11,4	0,7	106,3
3	Баяннуур	13,4	28,9	15,5	215,3
4	Бугат	32,2	67,9	35,7	211,0
5	Булган	53,9	101,2	47,4	187,9
6	Буянт	43,9	82,5	38,6	188,0
7	Дэлүүн	60,8	180,4	119,7	297,0
8	Ногооннуур	23,3	29,1	5,8	124,8
9	Сагсай	16,7	35,2	18,5	210,5
10	Толбо	29,4	22,0	-7,4	74,8
11	Улаанхус	41,8	35,6	-6,2	85,2
12	Цэнгэл	43,1	61,3	18,3	142,4
13	Цагааннуур	5,7	26,2	20,5	459,6

14	Өлгий	348,2	834,2	486,1	239,6
15	Татварын хэлтэс	4 727,4	4 016,8	-710,6	85,0
	<b>БҮГД</b>	<b>5 484,6</b>	<b>5 611,7</b>	<b>127,1</b>	<b>102,3</b>
	сумын дүн	<b>757,2</b>	<b>1 594,9</b>	<b>837,7</b>	<b>210,6</b>

Эх сурвалж: Орон нутгийн орлогын ерөнхий дансны хуулга

Эхний 9 сарын орлогын төлөвлөгөөг Толбо, Улаанхус сум 6,1-7,4 сая төгрөгөөр, аймгийн Татварын хэлтэс 710,6 сая төгрөгөөр тасалсан байна.

2018 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг аймгийн Татварын хэлтэсээс гаргуулан авахад дараах байдалтай байна.

Аймгийн Татварын хэлтэсээс гаргаж ирүүлсэн 2018 оны орон нутгийн суурь орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийтдээ 7938,8 сая төгрөгийн орлого орж, төлөвлөгөө 626,0 сая төгрөгөөр буюу 108,6 хувиар биелэгдэх төлөвтэй байна.

Хүснэгт №03

1	ᠶᠡᠨᠡᠭᠦᠨᠠᠨᠢ ᠲᠠᠭᠠᠷᠢᠨ ᠬᠡᠯᠡᠲᠦᠰ	/ сая төгрөгөөр/			
		төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	
				дүнгээр	Хувиар
	<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>7 312,80</b>	<b>7 938,80</b>	<b>626,0</b>	<b>108,6</b>
	<b>А.Урсгал орлого</b>	<b>7 312,8</b>	<b>7 938,8</b>	<b>626,0</b>	<b>108,6</b>
	<b>I.Татварын орлого</b>	<b>6 881,4</b>	<b>7 403,3</b>	<b>521,9</b>	<b>107,6</b>
	<b>1.Орлогын албан татвар</b>	<b>5 587,0</b>	<b>5 829,4</b>	<b>242,4</b>	<b>104,3</b>
	<b>1.1 ХАОАТатвар</b>	<b>5 587,0</b>	<b>5 829,4</b>	<b>242,4</b>	<b>104,3</b>
110001	ᠣᠠᠶᠢᠨ ᠲᠠᠭᠠᠷᠢᠨ ᠬᠡᠯᠡᠲᠦᠰ ᠲᠠᠭᠠᠷᠢᠨ ᠲᠠᠭᠠᠷᠢᠨ ᠬᠡᠯᠡᠲᠦᠰ	6 013,9	5 515,3	(498,6)	91,7
110002	Үйл ажиллагааны орлого	250,0	402,5	152,5	161,0
	Хөрөнгийн орлого	300,0	789,0	489,0	263,0
110004	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	70,0	78,4	8,4	112,0
110005	ШУУЗУБТБАЗБүтээх орлогын татвар	3,1	3,2	0,1	103,2
110101	ХХОАТатварын буцаан олголт	(1 050,0)	(959,0)	91,0	91,3
	<b>2.Өмчийн татвар</b>	<b>597,5</b>	<b>626,8</b>	<b>29,3</b>	<b>104,9</b>
113001	ᠲᠠᠭᠠᠷᠢᠨ ᠬᠡᠯᠡᠲᠦᠰ ᠲᠠᠭᠠᠷᠢᠨ ᠬᠡᠯᠡᠲᠦᠰ	251,5	274,6	23,1	109,2
113002	ᠠᠶᠢᠨ ᠲᠠᠭᠠᠷᠢᠨ ᠬᠡᠯᠡᠲᠦᠰ	48,0	40,8	(7,2)	85,0

	ÀÒªÛÖÀÒààààð	298,0	311,4	13,4	104,5
	<b>4.Бусад татвар</b>	<b>448,9</b>	<b>386,2</b>	<b>(62,7)</b>	<b>86,0</b>
118001	Óëñíí òýíàýàðëéí ðòðààíæ	305,0	277,5	(27,5)	91,0
118101	Ãàçðóí ð°ëá°ð	102,9	93,7	(9,2)	91,1
118006	Óçàýýýé ðàððàòòàé àøëàò íàëðíæ àøëàëáíí ð°ëá°ð	38,0	14,0	(24,0)	36,8
118009	Хог хягдалын үйлчилгээний хураамж	3,0	1,0	(2,0)	33,3
	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>248,0</b>	<b>560,9</b>	<b>312,9</b>	<b>226,2</b>
118203	Ус, рашаан ашигласны төлбөр	10,0	13,2	3,2	132,0
118201	Íëáíí хэрэглээний íñ,òçëýý áýëðáýæ àøëàëáíí ð°ëá°ð	45,0	46,7	1,7	103,8
118202	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	193,0	501,0	308,0	259,6
	<b>II.Татварын бус орлого</b>	<b>431,4</b>	<b>535,5</b>	<b>104,1</b>	<b>124,1</b>
120002	Хүүгийн орлого	220,00	307,90	87,9	140,0
	Төсөвт газрын өөрийн орлого	51,4	51,4	-	100,0
120009	Бусад нэр заагдаагүй орлого	160,0	176,2	16,2	110,1
	<b>Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Эх сурвалж: аймгийн татварын хэлтэс

Орлогын гүйцэтгэлийн нэр төрлөөр авч үзвэл: ХХОАТ 104,3 хувиар, өмчийн татвар 104,9 хувиар, байгалийн нөөц ашигласны төлбөрийг 226,2 хувиар, татварын бус орлого 112,2 хувиар биелэгдэж, бусад татвар 13,9 хувиар тасрах төлөвтэй гарчээ.

Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар 491,4 сая төгрөгөөр буюу 8,2 хувиар тасрах төлөвтэй байгаа нь ХХОАТ-ын орлогын дүн тасрах шалтгаан байх төлөвтэй байна.

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр сумын төсвийн орлого нийт дүнгээр 582,6 сая төгрөгөөр буюу 157,7 хувиар, аймгийн төсвийн орлого 43,5 сая төгрөгөөр буюу 101 хувиар биелэгдэх төлөвтэй гарчээ.

Хүснэгт №4		/сая төгрөгөөр/			
№	Сумын нэр	2018 оны ХБ гүйцэтгэл			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Сумын төсвийн орлого	1,009.5	1,592.1	582,6	157,7
2	Аймгийн төсвийн орлого	6,303.3	6,346.8	43,5	101,0
	<b>БҮГД</b>	<b>7,312.8</b>	<b>7,938.8</b>	<b>626,0</b>	<b>108,6</b>

Эх сурвалж: аймгийн татварын хэлтэс

Аймгийн Татварын хэлтсээс 2018 оны 2 дугаар улиралд ХХОАТ-ын тухай хуулинд орсон өөрчлөлтөөр хөнгөлөх татварын хэмжээ шаталбараар нэмэгдсэнээс цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар оны эцэст 604,1 сая төгрөгөөр тасарч, харин хадгаламжийн хүүгийн болон торгуулийн орлого төлөвлөснөөс давах төлөвтэй гэсэн тооцоо гаргасан байна.

Хадгаламжийн хүүгийн орлогоос 9 дүгээр сарын 30-ны байдлаар 708,9 сая төгрөгийн орлого орсон ба хүлэгдэж буй гүйцэтгэлээр нэмэгдэх төлөв харагдаж байна.

### **Орон нутгийн төсвийн тусламжийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар:**

2018 онд Орон нутгийн төсөвт улсын төсвөөс тусламжийн орлогоор нийт 69147,2 сая төгрөгийн санхүүжилт авахаас эхний 9 сарын гүйцэтгэлээр 49169,5 сая төгрөгийн санхүүжилт авч, 19977,7 сая төгрөгийн санхүүжилтийг үлдсэн хугацаанд авах тооцоо гарч байна.

Хүснэгт №05		/сая төгрөгөөр/			
Орлогын ангилал	жилийн дүнгээр олгох дэмжлэг	Эхний 9 сард олгосон дэмжлэг	зөрүү	хувь	
<b>Улсын төсвийн дэмжлэг</b>	16407,9	11339,2	5068,7	69,1	
<b>ОНХСангийн шилжүүлэг</b>	4940,7	2623,5	2317,2	53,1	
<b>ТЗШилжүүлэг</b>	47798,6	35206,8	12591,8	73,6	
<b>Бүгд дүнгээр</b>	<b>69147,2</b>	<b>49169,5</b>	<b>19977,7</b>		
<b>Орон нутгийн хөрөнгө оруулалт</b>	3893,3	2269,7	1623,6		

Эх сурвалж: Санхүү, Төрийн сангийн хэлтэс

ОНХСангийн орлогын шилжүүлгээр эхний 9 сард 3795,3 сая төгрөгийн орлого хүлээн авахаас 2623,5 сая төгрөг авч төлөвлөснөөс 1171,8 сая төгрөг дутуу олгогдсон байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээр эхний 9 сард авах 35152,0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтад нийт 3893,3 сая төгрөгийг суурь зарлагад суулгаж өгснөөс 9 сарын гүйцэтгэлээр 2269,7 сая төгрөгийн санхүүжилт авсан ба үлдсэн хугацаанд 1623,6 сая төгрөгийн санхүүжилтийг авах тооцоо гарч байна.

*2.2. Төсөвт болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудаас төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж байхгүй байна.*

Аймгийн ИТХ-аас 2018 онд орон нутгийн төсөвт байгууллагуудаас нийт 99,7 сая төгрөгийн орлого оруулахаар төсөвт нь тусгаж өгсөн байна.

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт байгууллагууд 58,1 сая төгрөгийн, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд 45,6 сая төгрөгийн бүгд 103,7 сая төгрөгийн орлого оруулах боломж байна.

Хүснэгт №06		/сая төгрөгөөр/		
№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
	Бүгд дүнгээр	99,7	103,7	4,0
1	Орон нутгийн төсөвт байгууллагууд	51,4	58,1	6,7
2	ТЗШ-ийн байгууллагууд	48,3	45,6	-2,7

Эх сурвалж: Санхүү, Төрийн сангийн хэлтэс

Төсөвт байгууллагуудаас төлөвлөснөөс илүү төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж байхгүй байна гэж үзлээ.

Тус аймагт орон нутгийн өмчийн ЦШСГазар, “Суат” ХХК, “Жана өлке”, “Хала өркени” ОНӨААТҮГазар зэрэг 4 аж ауйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. 2017 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайланг зэрэгцүүлж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №07		/сая төгрөгөөр/			
Байгууллагуудын нэрс	ЦШС-ний газар	СУАТ	Жана өлке	Хала өркени	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	2084,6	153,2	-	19,9	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2352,6	244,2	130,9	176,8	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-268,0	-91,0	-130,9	-156,8	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-0,6				
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-268,6	-91,0	-130,9	-156,8	

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн тайлангийн нэгтгэл

Эдгээр аж ахуйн нэгжүүд НӨАТ, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар, газрын төлбөр, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төсөвт төлж байна. 2018 оны эхний 9 сарын гүйцэтгэлээрх татвар төлөлтийн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №08		/сая төгрөгөөр/					
ААН, ҮГ-ын нэр	татварын төрөл	оны эхний үлдэгдэл		ногдуулсан	төлсөн	эцсийн үлдэгдэл	
		дутуу	илүү			дутуу	илүү

Жана өлке	газрын төлбөр	0,4				0,4	
	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого /суутган-1/	3,1				3,1	
	<b>бүгд</b>	<b>3,5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3,5</b>	<b>0</b>
Хала өркени	ААН-ийн орлогы албан татвар		0,1				
	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого /суутган-1/	4,6		0,7	0,9	4,3	0,1
	<b>бүгд</b>	<b>4,6</b>	<b>0,1</b>	<b>0,7</b>	<b>0,9</b>	<b>4,3</b>	<b>0,1</b>
СУАТ ХХК	ус ашигласны төлбөр	3,3			4,3		1
	дотоодын бараа үйлчилгээний НӨАТ	108		53,6	26,5	135,2	
	үл хөдлөх хөрөнгийн татвар	2,1		2,1	4,2		
	хувь хүнээс суутгасан орлогын албан татвар				7,0		7,0
	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого /суутган-1/	7,1		22,8	20,3	9,6	
	<b>бүгд</b>	<b>120,5</b>	<b>0</b>	<b>78,5</b>	<b>62,3</b>	<b>144,8</b>	<b>8,0</b>
ЦШС-ний газар	газрын төлбөр			1	1	0	
	дотоодын бараа үйлчилгээний НӨАТ	68,0		237,2	375,5		70,3
	үл хөдлөх хөрөнгийн татвар	2,4		2,4	2,4	2,4	
	хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	0,1		4,6	1,8	3,6	
	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого /суутган-1/			68,2	68,0	0,2	
	<b>бүгд</b>	<b>70,5</b>	<b>0</b>	<b>313,4</b>	<b>448,7</b>	<b>6,2</b>	<b>70,3</b>
	<b>нийт дүнгээр</b>	<b>199,1</b>	<b>0,1</b>	<b>392,6</b>	<b>511,9</b>	<b>158,8</b>	<b>78,4</b>

Эх сурвалж: Аймгийн татварын хэлтэс

Аж ахуйн нэгжүүд тайлант онд 392,6 сая төгрөгийн татвар ногдуулж, 511,9 сая төгрөгийг төлсөн байна.

Аймгийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

## Бүлэг 3

Орон нутгийн төсөвт байгууллагууд нийтдээ 2358,4 сая төгрөгийн өртэй гарах төлөвтэй байна.



**Бүлэг 3 Орон нутгийн төсөвт байгууллагууд нийтдээ 2358,4 сая төгрөгийн өртэй гарах төлөвтэй байна.**

*3.1. Орон нутгийн төсөвт байгууллагууд 2018 оны эцэст хүлээгдэж буй гүйцэтгэлээр батлагдсан төсвөөс 2358,4 сая төгрөгийн илүү зарлага гаргаж, өр үүсгэх болзошгүй байна.*

Аймгийн ИТХ-ын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 37 дугаар хуралдаанаар аймгийн төсөвт тодотгол хийж, сумуудын төсвийг нэгтгэснээр 2018 оны төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 78661,1 сая төгрөг байна.

- Орон нутгийн бүх төсөвт байгууллагуудаас 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргуулан авч, Санхүү төрийн сангийн хэлтсийн “Пластик” программаар нэгтгэж гаргав.

Хүснэгт №	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2018 он			/сая.төг/
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Урьдчилсан гүйцэтгэл	
Б		1	2,0	3,0	4	5=4-3
	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>71 282,9</b>	<b>77 049,5</b>	<b>78 661,1</b>	<b>81 019,50</b>	<b>2 358,40</b>
	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>69295,7</b>	<b>69 754,3</b>	<b>71 329,6</b>	<b>74037</b>	<b>2 707,40</b>
	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>52046,6</b>	<b>52 527,5</b>	<b>54 034,7</b>	<b>54942,9</b>	<b>908,20</b>
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	35 254,8	34 922,1	35 055,3	36 927,4	<b>1 872,10</b>
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3 875,6	4 192,1	4 205,5	4 469,3	<b>263,80</b>
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4 530,9	5 106,5	5 086,9	5 385,3	<b>298,40</b>
	Хангамж, бараа материалын зардал	914,2	912,3	942,2	1 023,0	<b>80,80</b>
	Нормативт зардал	3 782,5	4 085,1	4 084,3	3 959,2	- <b>125,10</b>
	Эд хогшил, урсгал засварын зардал	242,2	156,5	183,9	210,5	<b>26,60</b>
	Томилолт, зочны зардал	172,0	197,8	199,4	216,6	<b>17,20</b>
	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>991,0</b>	<b>965,5</b>	<b>734,6</b>	<b>1079</b>	<b>344,40</b>
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	991,00	891,4	660,9	1003,8	<b>342,90</b>
	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		39,8	39,7	39,3	- <b>0,40</b>
	Даатгалын үйлчилгээ		7,1	6,9	6,9	-
	Тээврийн хэрэгслийн татвар		4,0	3,9	3,9	-
	Тээврийн хэрэгслийн оношлогоо		1,4	1,4	1,4	-
	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		11,0	11,0	11,8	<b>0,80</b>
	Газрын төлбөр		3,5	3,5	3,4	- <b>0,10</b>

Банк, СБ-ын үйлчилгээний хураамж		6,6	6,6	7,8	1,20
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		0,7	0,7	0,7	-
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2283,4</b>	<b>1 989,6</b>	<b>3 542,6</b>	<b>1672,6</b>	<b>- 1 870,00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	2 283,40	1 716,7	3 265,9	1387,9	- 1 878,00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		272,9	276,7	284,7	8,00
<b>ХҮҮ</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр					-
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр					-
<b>ТАТААС</b>	<b>77,3</b>	<b>79,8</b>	<b>79,8</b>	<b>79,8</b>	<b>-</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас					-
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	77,30	79,8	79,8	79,8	-
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17 171,8</b>	<b>17 147,0</b>	<b>17 215,1</b>	<b>19014,3</b>	<b>1 799,20</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>17 171,8</b>	<b>1 168,0</b>	<b>1 318,3</b>	<b>1482,6</b>	<b>164,30</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	17 171,80	1 168,0	1 318,3	1482,6	164,30
Засгийн газрын гадаад шилжүүлэг					-
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0</b>	<b>15 979,0</b>	<b>15 896,8</b>	<b>17531,7</b>	<b>1 634,90</b>
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		11 877,6	11 877,6	13908,8	2 031,20
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		2,2	2,2		- 2,20
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал				2,7	2,70
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		1 095,9	1 095,9	974	- 121,90
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт					-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		673,0	699,4	672,7	- 26,70
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан АХ-дад төрөөс үзүүлэх дэмжлэг		980,1	980,1	944,2	- 35,90
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1 350,2	1 241,6	1029,3	- 212,30
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1987,2</b>	<b>7 295,2</b>	<b>7 331,5</b>	<b>6982,5</b>	<b>- 349,00</b>
Барилга байгууламж		3 544,6	3 556,1	3544,5	- 11,60
Их засвар		2 228,7	2 228,7	2228,7	-
Тоног төхөөрөмж		631,4	647,2	633,4	- 13,80
Бусад хөрөнгө	1 987,20	890,5	899,5	575,9	- 323,60
Стратегийн нөөц хөрөнгө					-
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>
Эргэж төлөгдөх зээл					-
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл					-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл					-
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>71192,1</b>	<b>77 049,5</b>	<b>78 661,1</b>	<b>81023,9</b>	<b>2 362,80</b>
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	49 011,70	47 757,6	47 744,0	49386,6	1 642,60
Орон нутгийн төсвөөс санхүүжих	18 919,30	23 753,0	23 759,4	26098,1	2 338,70
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1 655,40	4 940,6	4 569,8	4940,6	370,80
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1 605,70	598,3	2 587,9	598,6	- 1 989,30
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих					-
Бусад эх үүсвэр					-
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>201</b>	<b>232,5</b>	<b>232,5</b>	<b>0</b>	<b>- 232,50</b>
Төсвийн байгууллага	189	224,0	224,0		- 224,00
Төсвөөс гадуур байгууллага	12	8,5	8,5		- 8,50
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>5023,5</b>	<b>4 419,0</b>	<b>4553</b>	<b>4756</b>	<b>203,0</b>
Удирдах ажилтан	271	261,0	261,0	253	8,0
Гүйцэтгэх ажилтан	2950	2 593,5	2727,5	2651,0	76,5
Үйлчлэх ажилтан	1486,5	1 249,5	1249,5	1502	252,5
Гэрээт ажилтан	316	315,0	315,0	350	35,0

<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО ( жилийн дунджаар )</b>	<b>27877</b>	<b>23 209,0</b>	<b>23 209,0</b>	<b>0</b>	<b>-23 209,00</b>
Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	27877	23 209,0	23 209,0	0	-23 209,00
Төрийн өмчит ЕБС	23062	20 671,0	20 671,0		-20 671,00
Хувийн өмчит ЕБС	4815	2 538,0	2 538,0		- 2 538,00
Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад	0	-	-	0	-
Төрийн өмчит СӨБ байгууллагад					
Хувийн өмчит СӨБ байгууллагад					

Эх сурвалж: Аймгийн ТЕЗийн 2017 оны тайлан, Санхүү, төрийн сангийн хэлтэс, төсөвт байгууллагуудаас ирүүлсэн судалгаа

Орон нутгийн төсөвт байгууллагууд оны эхэнд батлагдсан 78661,1 сая төгрөгийн төсвөөр ажиллаж, хүлээгдэж байгаа төсвийн гүйцэтгэл 81019,5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч төсвөө 2358,4 сая төгрөгөөр хэтрүүлэн, өртэй гарах төлөвтэй байна.

Зардлын зүйл ангиар үзвэл: цалингийн зардал 1872,1 сая төгрөгөөр, НДШ-ийн зардал 263,8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 298,4 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 80,8 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал зардал 26,6 сая төгрөгөөр, томилолт зочны зардал 17,2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардал 344,4 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 1799,2 сая төгрөгөөр хэтэрч, нормативт зардал 125,1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1870,0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 349,0 сая төгрөгөөр хэмнэгдэх тооцоо гарч байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудад нийтдээ 4756 хүн ажиллаж, батлагдсан орон тоог 203 хүнээр хэтрүүлэн ажиллуулсан байна.

Орон тооны хэтрэлтээс шалтгаалан цалин, НДШ-ийн зардал хэтэрч өр үүсэхэд нөлөөлсөн байна. 2018 оны цалингийн зардалд 35055,3 сая төгрөг батлагдсан бөгөөд өмнөх оноос 199,5 сая төгрөгөөр доогуур байгаа нь орон тооны хэтрэлт өмнөх оноос үргэлжилж төсөвт ачаалал үүсгэж өртэй гарахад нөлөөлж байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал дотор түлш халаалтын зардал 298,4 сая төгрөгөөр хэтэрч байгаа нь нэгдсэн халаалтанд холбогдсон сумуудын халаалтын зардал доогуур төлөвлөгдөж байгаатай холбоотой байна.

Халамжийн сангийн төсөв 1982,6 сая төгрөгөөр хэтрэх төлөвтэй, 9 сарын сарын 30-ын байдлаар 1630,0 сая төгрөгийн өртэй байна. Жилийн эцсийн нийт өрийн 84,0 орчим хувийг халамжийн сангийн өр эзлэх тооцоо гарч байна.

-2018 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр төсвийн нийт зарлага 53308,0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч байна.

Санхүү төрийн сангийн хэлтсээс 9 дүгээр сарын 30-ны байдлаарх системд бүртгэгдсэн төсөвт байгууллагын нийт өрийн хэмжээ 3785,6 сая төгрөгт хүрсэн байна. Үүнд: 860,9 сая төгрөгийн цалингийн, 937,4 сая төгрөгийн НДШ-ийн, 1422,7 сая төгрөгийн бусад зардлын өр гарчээ.

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр аймгийн төсөвт байгууллагууд оны эцэст 2358,4 сая төгрөгийн өртэй гарах төлөвтэй байна. Тухайлбал: Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 1872,1 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 263,8 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 298,4 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 80,8 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 26,6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 344,4 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 1799,2 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулах төлөвтэй байна.

**- Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл:** Аудитын явцад орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг анхан шатны баримт материалтай тулган шалгаж, сумдад хэрэгжиж буй төсөл арга хэмжээний судалгааг гаргалаа.

*ОНХСанг зориулалтын дагуу зарцуулж ирсэн байна.*

Аймгийн ОНХСанд нийт 2451,7 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөгдсөнөөс шилжих хөрөнгө оруулалтад 382,4 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 1984,0 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 85,3 сая төгрөг 35 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн ОНХСангийн дансны эхний үлдэгдэл 1,2 сая төгрөг ба эхний 9 сард 2623,5 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хүлээн авч, 2607,4 сая төгрөгийг зарцуулж, 9 дүгээр сарын 30-нд 1408,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс 1199,1 сая төгрөгийг сумын ОНХСанд хуваарилж, 1408,3 сая төгрөгийг аймгийн ОНХСангаас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтэд олгосон байна.

Аймгаас хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэл:

хүснэгт №09		/сая төгрөгөөр/			
	Төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг /аймгийн нийт дүнгээр/	2018 онд санхүүжих дүн	Эхний 9 сарын байдлаар олгосон дүн	9 зөрүү
1.1	Шилжих хөрөнгө оруулалт	498,2	382,4	324,4	58,0
1.2	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	4094,6	1984,0	1039,7	944,3
1.3	Тоног төхөөрөмж	85,3	85,3	24,3	6,1
	Баяр наадмын зардал			19,8	-19,8
	Бүгд дүнгээр	4592,8	2451,7	1408,3	

Эх сурвалж: Санхүү, төрийн сангийн хэлтэс

Шилжих хөрөнгө оруулалтад 324,4 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 1039,7 сая төгрөг, тоног төхөөрөмж авахад 24,3 сая төгрөг тус тус олгожээ.

Аймгийн 2018 оны төсвийг батлахдаа аймгийн баяр наадмын зардлыг ОНХСангийн төсөвт суулгаагүй орхигдуулж, наадмын зардалд гарах 19,8 сая

төгрөгийг ОНХСангийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр аймгийн Засаг дарга захирамж гарган зарцуулсан байна.

### **3.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвөөс 56,6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.**

Аймгийн ИТХ-ын тогтоолоор аймагт хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтанд шилжих хөрөнгө оруулалтад 124,7 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 2172,9 сая төгрөг, тоног төхөөрөмж бэлтгэхэд 427,6 сая төгрөг, бүгд 2725,2 сая төгрөг баталсан байна.

Аймгийн ОН-ийн хөрөнгө оруулалтын дансанд оны эхэнд 20,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба эхний 9 сард 1074,1 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, 1068,0 сая төгрөгийг зарцуулж, 9 дүгээр сарын 30-нд 26,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

хүснэгт №09		/сая төгрөгөөр/			
	Төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг	2018 онд санхүүжих дүн	Эхний 9 сарын байдлаар олгосон дүн	9 зөрүү
1.1	Шилжих хөрөнгө оруулалт	124,7	124,7	81,6	43,1
1.2	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	2172,9	2172,9	665,4	1507,5
1.3	Тоног төхөөрөмж	427,6	427,6	264,5	163,1
	Эргэн төлөгдөх нөхцөлөөр			56,5	-56,5
	<b>Бүгд</b>	<b>2725,2</b>	<b>2725,2</b>	<b>1068,0</b>	

Эх сурвалж: Санхүү, төрийн сангийн хэлтэс

Эрх шилжсэн хөрөнгө оруулалтад 81,6 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 665,4 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах арга хэмжээнд 264,5 сая төгрөг зарцуулж, аймгийн Засаг даргын захирамжаар бусад үйл ажиллагаанд эргэн төлөгдөх нөхцөлөөр 56,5 сая төгрөг олгож, зориулалт бусаар зарцуулсан байна.

#### **3.1.2 Эрх шилжсэн хөрөнгө оруулалт гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.**

Эрх шилжсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Барилга, хот байгуулалтын сайдын багцаас 8656,2 сая төгрөгийн өртөгтэй 4 төсөл арга хэмжээ, БСШУСайдын багцаас 5954,4 сая төгрөгийн өртөгтэй 6 төсөл арга хэмжээ, ХХААХҮСайдын багцаас 285,0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, Зам тээврийн сайдын багцаас 140,0 сая төгрөгийн өртөгтэй 3 төсөл арга хэмжээ, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын багцаас 80,0 сая төгрөгийн өртөгтэй 1 төсөл арга хэмжээ, бүгд 16 төсөл арга хэмжээг эрх шилжүүлсэн байна.

Эрх нь шилжсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

- Барилга, хот байгуулалтын сайдын багцаас эрх шилжсэн 4 төсөл арга хэмжээнээс 3 нь гэрээ хийгдэж, гүйцэтгэх шатанд байна. Тайлант онд санхүүжих дүн нь 974,8 сая төгрөг ба 99,7 сая төгрөгийг олгосон байна. 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгараагүй байна.
- БСШУСпортын сайдын багцаас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс тайлант онд 4269,9 сая төгрөгийн өртөгтэй 5 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээс гэрээ хийгдэж, гүйцэтгэлээр 565,6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгараагүй байна.
- ХХААХҮСайдын багцаас эрх шилжсэн 2 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч нь гэрээ хийж, ажил нь хийгдэж байгаа ба тайлант онд 285,0 сая төгрөг санхүүжүүлэхээс одоогоор санхүүжилт олгоогүй байна.
- Зам тээврийн сайдын багцаас хэрэгжих 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч нь шалгарч, ажлаа гүйцэтгэж байна.
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын багцаас 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулж, гэрээ хийж, ажил нь хийгдэж байна.

ГХБХБГазраас улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хэрэгжилтэнд зохих журмын дагуу хяналтаа тавьж ажилласан байна.Тус газраас ирүүлсэн ажлын мэдээ тайлангаар:

- МУ-ын ерөнхий сайдын багцаас хийгдэж буй 2 төсөл арга хэмжээ 100 хувийн гүйцэтгэлтэй,
- Барилга, хот байгуулалтын сайдын багцаас хийгдэж буй 3 ажлын 2 нь гэрээ байгуулах шатанд, 1 ажил нь 80%-ийн гүйцэтгэлтэй,
- БСШУСайдын багцаас хийгдэж буй 8 төсөл арга хэмжээний 1-ийх нь тендер маргаантай бусад нь 18-80 хувийн гүйцэтгэлтэй,
- Эрүүл мэндийн сайдын багцаас хийгдэж буй 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 5-98 хувийн гүйцэтгэлтэй,
- ХХААХҮСайдын багцаар хийгдэж буй 2 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 70 хувьтай,
- Турк улсын Тика төслийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 75 хувьтай байна.

Аудитын явцад ОНХСан, орон нутгийн хөрөнгө оруулалт, улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явцыг Цэнгэл, Улаанхус, Буянт сумдаар явж зурагжуулсан. Аудитын явцад хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй.Төсөл арга хэмжээний явцын байдал дараах байдалтай байна.Үүнд:

- Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Улаанхус сумын Согог багийн төмөр бетон гүүрийн ажлын явц дараах байдалтай байна.





- ОНХ сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй Улаанхус сумын Согог багийн 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын явц



- Улаанхус сумын төвийн 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын явц





- ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжиж буй Улаанхус сумын нутгийн удирдлагын ордоны ажлын явц



- ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй Буянт сумын дотуур байрны их засварын ажлын явц
- 



- Сумын ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй трансформаторын ажлын гүйцэтгэл



*3.2 3 дугаар улирлын дүнгээр ОНХСан, ОНХО-ын 15 төсөл арга хэмжээний тендер зарлагдаагүй байна.*

Аймгийн ОНӨГазраас ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний бараа ажил үйлчилгээ худалдан авах тендер зарласан эсэхийг тулган шалгалаа.

Үүнд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 74 төсөл арга хэмжээнээс 10 төсөл арга хэмжээнд нээлттэй тендер шалгаруулалт, 32 төсөл арга хэмжээнд харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт явуулж, 21 төсөл арга хэмжээнд шууд гэрээ хийсэн байна.

ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 28 төсөл арга хэмжээний 7 төсөл арга хэмжээнд нээлттэй тендер шалгаруулалт, 15 төсөл арга хэмжээнд харьцуулалтын аргаар шалгаруулалт явуулж, 3 төсөл арга хэмжээнд шууд гэрээ хийсэн байна.

2018 оны 9 сарын 24-ний байдлаар ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөр арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээ буюу Ногооннуур сумын Ховд багийн бага сургуулийн засварын ажил, Өлгий сумын 12-р багийн ахмадуудын амралт, хүүхдийн тоглоомын талбай зэрэг ажлуудад тендер зарлагдаагүй байна.

ОНХСангийн төсвөөс зарласан тендерүүдээс 3 төсөл арга хэмжээнд явуулсан тендерийн үйл ажиллагаа нь амжилтгүй болж, 2 тендерийн үйл ажиллагаанд гомдол гарсан гэж тайлагнасан байна.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнээс 12 төсөл арга хэмжээнд тендер зарлаагүй, зарласан тендерээс 15 тендерийн үйл ажиллагаа амжилтгүй болсон байна гэсэн мэдээ ирүүлсэн байна.

Аймгийн 2018 оны төсвийн хэрэгжилтийн явц

## **Бүлэг 4**

ТЕЗ-ийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохих журмаар тайлагнаагүй байна.

#### **4. ТЕЗ-ийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохих журмаар тайлагнаагүй байна.**

*4.1 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг зохих журмаар баталсан байна.*

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6-д “төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах”, 22 дугаар зүйлийн 22.2.3-в “эдийн засгийн ангиллаар”, 22.2.4-т “хөтөлбөрөөр”, 22.2.5-д “арга хэмжээгээр”, 22.2.6-д “санхүүжүүлэх эх үүсвэрээр” гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит V дугаар хуралдааны 26 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар аймгийн төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнд хамаарах 13 байгууллага, салбарын 2018 онд хэрэгжүүлэх 41 хөтөлбөрт 47 арга хэмжээний хүрэх үр дүнг төлөвлөж баталсан байна.

ТЕЗ-ийн 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

- Орон нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд 4 хөтөлбөр,
- Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх ажлын хүрээнд 15 хөтөлбөр,
- Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын салбарт 7, СӨБ-ын салбарт 5, соёл урлагийн салбарт 4 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталжээ.

Хавсралтад тусгасан хөтөлбөр тус бүрд хүрэх үр дүнг тодорхой тусгаж, хийгдэх ажлын тоо, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвлөж тусгасан нь хуулийн дээрх заалтад нийцсэн байна.

*4.2 ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг зохих журмын дагуу дүгнэж тайлагнаагүй байна.*

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2018 оны 3 дугаар улирлын байдлаар ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн биелэлтийг гаргаж ирүүлсэн байна. Үүнд:

- Орон нутгийн өөрийн удирдлага хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 5 дэд хөтөлбөр гаргаж, хөтөлбөрийн биелэлтийг хангаснаар 318,6 сая төгрөгийн төсвийг зарцуулна гэж үзсэн байна. Энэ хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн гэж үзжээ. Тухайлбал:

-Нутаг дэвсгэрийн хэмжээнд нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Үндсэн чиглэлийг боловсруулахдаа аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан, биелэх боломжгүй зарим ажлуудыг дахин төлөвлөлтөд оруулж, гүйцэтгэлийг хангах зарчмыг баримтлан 5 хөгжлийн салбарт 2018 онд 218 зорилт, 343 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

-Аймгийн ИТХ-ын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит VI хуралдаанаар аймгийн 2017 оны давсан орлогын үлдэгдэл, хэмнэгдсэн зардлыг тодотгох, 2018 оны орон нутгийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт оруулах, Газрын харилцааны талаар авах зарим арга хэмжээний тухай, Аймгийн дэд хөтөлбөрүүд батлах тухай, Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам батлах, Аймгийн төвд болсон үер усны гамшигт өртөж хохирол учирсан иргэдийн тоо, хохирлын хэмжээ, иргэдийн хохирлыг барагдуулах ажлын явц, гамшигт нэрвэгдсэн иргэдэд зориулж төр засгаас болон гадаадын орнууд, байгууллага, иргэдээс өгсөн тусламж, хандивын зарцуулалтын тайлан мэдээллийг сонсох зэрэг цаг үеийн асуудлуудыг авч хэлэлцсэн байна.

-Аймгийн ИТХ-ын даргад 2018 онд иргэдээс 173 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг харьяаллын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлж хариу өгчээ.

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд төлөвлөгөө гаргаж биелэлтийг нь хангуулан, сургалт зохион байгуулж, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажил зохион байгуулсан.

- Аймгийн Засаг Дарга Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 15 хөтөлбөр арга хэмжээнд 23380,4 сая төгрөгийн төсөв зарцуулах ба дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

-Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд үндсэн 5 бүлэг, 23 дэд бүлгийн 218 зорилтыг хэрэгжүүлэх 332 арга хэмжээ тусгагдаж, эдгээр зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нь зохион байгуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцан салбар бүрийн зорилтуудыг холбогдох газар, хэлтэс, байгууллагуудаар биелэлтийг хангуулах арга хэмжээ авч ажиллажээ.

-2018 оны 9 дүгээр сарын байдлаар Засгийн газрын тус аймагт холбоотой 68 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 104 заалтыг хяналтад авч, орон нутагт хэрэгжүүлэх, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулжээ. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг холбогдох хэлтсийн дарга, байгууллагын салбар хариуцсан

мэргэжилтэн, агентлагуудад тухай бүрд нь танилцуулж хувилан олшруулж өгч биелэлтийг ТЗУХ-ээр гаргуулан хянах, мэдээ цуглуулах, үнэлгээ өгч ажиллажээ.

-2018 оны 1, 2 дугаар сард бүх сумдын 2017 оны үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-аас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ажлыг дүгнэж "Тэргүүний сум"-ыг шалгаруулж дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн байна.

Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай МУ-ын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай Засгийн газрын 2018 оны 218, 220 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны А/553 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын А/664 тоот захирамжаар байгуулагдсан 7 ажлын хэсэг 13 сумын захиргааны байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлын хангалт, хөрөнгө оруулалтын ажлын явц, сахилга хариуцлага, дэг журмыг баримтлан ажиллаж байгаа байдалд гэнэтийн хяналт-шалгалт хийжээ.

-Төрт үйлчилгээг ард иргэдэд нээлттэй ил тод болгох үүднээс аймгийн цахим хуудсанд иргэдэд хүлээн авах төвд гэсэн цэс ажиллуулж иргэдийн өргөдөл, санал гомдлын тайланг улирал бүр байршуулж, ЗДТГ-ын үүдэнд саналын хайрцаг тавьж ажиллуулсан байна.

-“Өлгий ньос” нэртэй вэб сайт ажиллуулж, орон нутгийн радио нэвтрүүлгийг өдрийн цагаар давтан дамжуулж, Орон нутагт 3 телевиз тогтмол үйл ажиллагааг явуулж, аймгийн өдөр тутмын мэдээ мэдээллийг иргэдэд шуурхай хүргэн ажиллаж байгаа ба “Заман”, “Монгол Заман” сонин сэтгүүл тогтмол гарч хот, хөдөөгийн уншигч нарт очиж байна.

-Орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, өмчийн хадгалалт хамгаалалт, ашиглалтад хяналт тавих, худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, ашиглах хугацаа нь дууссан, элэгдлийн хэмжээ нь дуусаагүй боловч ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг актлах хөрөнгийн материалыг бүрдүүлэн газар дээр нь шалгаж Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд танилцуулан холбогдох хууль журмын дагуу тогтоол гаргуулан ажиллажээ.

-Засаг дарга БОАЖСайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 8 төрлийн ажлыг гүйцэтгэжээ.

-БОАЖЯ-ны харьяа “Ойн судалгаа, хөгжлийн төв”-ийн даргатай Баяннуур сумын нутагт улсын төсвийн хөрөнгөөр 5 га газарт “Ногоон хэрэм”-ийн ойн туслах зурвас байгуулах шууд гэрээ байгуулж, гүйцэтгэжээ.

-Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль болон бусад журам, дүрэм, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг

ханган ажиллаж 2018 оны эхний 9-н сарын байдлаар Нийгмийн халамжийн сангаас 3335 ахмад настанд 503,7 сая төгрөгийн хөнгөлөлт олгосон.

-Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний хүрээнд харж хандах хүнгүй, хүнд нөхцөлд амьдарч байгаа иргэдийн асуудлыг хууль журмын дагуу асрамжийн төвд асруулагчаар оруулж, жилд нэг удаа асруулагч нараас сэтгэл ханамжийн судалгаа авч холбогдох байгууллагад хүргүүлж ажиллажээ.

-Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийж үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгч, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллажээ.

-Халдварт өвчнөөс сэргийлэх тарилгад бүх малыг бүрэн хамруулж сар бүр мэдээ тайланг авч ажилласан байна.

-ОНХСангийн хөрөнгийг Төсвийн тухай хууль, ОНХСангийн журмын дагуу ил тод, иргэдийн саналыг авсны дагуу аймгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан 35 төсөл арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

- Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд 29 төрлийн ажлын биелэлтийг гаргаж ирүүлсэн байна. Хүрсэн үр дүнг товчилж тусгавал дараах байдалтай байна.

-ЕБС-ийн 16 бага сургууль, ЕБС-д бага ангийн боловсрол эзэмшихээр 11025 хүүхэд хамрагдсан ба энэ үзүүлэлт урьд оныхоос 9 хувиар нэмэгджээ. Өндөр насны тэтгэвэрт гарсан 40 багш, ажилтанд 425,8 сая төгрөгийн, 5 жилийн тэтгэмжид 185 хүнд 611,6 сая төгрөг олгожээ.

-Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Өлгий сумын 9-р багт 150 хүүхдийн цэцэрлэг баригдаж ашиглалтад орж, 6-р цэцэрлэгийн өргөтгөлийн ажил хийгдэж, Ногооннуур сумын Улаанхад багт 50 хүүхдийн цэцэрлэг, сумын төвд 100 хүүхдийн цэцэрлэг шинээр баригдаж байна.

-СӨБ-д ажилладаг 8 ажилтанд 109,2 сая төгрөгийн, 124 хүнд 368,4 сая төгрөгийн таван жилийн тэтгэмж олгогдсон байна.

-Номын сангийн Lib-4U программ ашиглан дотоод сүлжээнд холбогдон фондын номыг 100% электрон каталогт оруулах ажил хийгдэж байгаа ба Lib-4U цогц программыг шинэчлэхээр БСШУСЯ-д 3,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг хүргүүлсэн байна.

-Хөгжимт Драммын Театр “Улаан малгайт охин” хүүхдүүдэд зориулсан хөгжимт жүжгийг 5 дугаар сард 8 удаа тоглож, үзэгчдийн хүртэл болгож, хөдөө



сумдаар аялан тоглолт хийж соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүргэж, өөрийн орлогын төлөвлөгөөг 100% биелүүлж, үзэгчдийн тоог 20%-иар ахиулсан байна.

-Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хөдөө сумдын 13 ЭМТөв, аймгийн төвд 4 өрхийн ЭМТөвөөр дамжуулсан ард иргэдэд тасралтгүй үзүүлж байна. Эхийн эндэгдэл буурсан үзүүлэлттэй гарч, жирэмсэн эхийн хяналт 98 хувь, дархлаажуулалт 99 хувьд хүрч, халдварт өвчин буурсан үзүүлэлттэй байна.

-Үндэсний спортын YI их наадмын анхан шатны тэмцээнийг аймагт зохион байгуулж, Улаанбаатар хотод 2018 оны 08 дугаар сард зохион байгуулагдсан шигшээ тэмцээнд баг тамирчид амжилттай оролцож, сур харвааны тамирчид шагналт 5-р байранд шалгарчээ.

-Хот байгуулалтын хэсэгчилсэн төлөвлөгөө хийгдээгүй, дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй газраас иргэдэд шинээр газар олгосон,

-Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын 2.87.4 заалтын дагуу Баруун бүсэд байгуулах цементийн үйлдвэрийг дэмжих бодлогын хүрээнд 2018 оны 9 сард “Өлгий цемент” үйлдвэр, 2.87.1 заалтын дагуу угсармал барилгын үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд “Агайын” ХХК төмөр бетон нүхтэй хавтангийн үйлдвэр тус тус ашиглалтад оржээ.

-Хүүхдийн оролцоог дэмжих стратеги хөтөлбөрийг 2012-2016 оны хооронд хэрэгжүүлсэн зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Санхүү төрийн сангийн хэлтсээс ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг харьяа хэлтэс, байгууллагуудаас гаргуулан авч нэгтгэж дэлгэрэнгүй тайланг ирүүлсэн.

Гэвч ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хэрэгжилт хэдэн хувьтай байгааг дүгнээгүй, эхний 9 сарын гүйцэтгэлээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулсан төсвийн хэмжээг тодорхой тусгаж ирүүлээгүй байна.

Иймд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг хуулийн хүрээнд хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зарцуулж байгаа боловч хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна.

*4.3. Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.*

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүргийг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэж заасны дагуу төсвийн захирагчид хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүрэгтэй байна.



ЗДТГ-ын хяналт үнэлгээний хэлтсээс Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг дүгнэж, Засгийн газраас ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж ажилласан талаар ажлын тайланд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.Үүнд:

-Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд үндсэн 5 бүлэг, 23 дэд бүлгийн 218 зорилтыг хэрэгжүүлэх 332 арга хэмжээ тусгагдаж, эдгээр зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нь зохион байгуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцан салбар бүрийн зорилтуудыг холбогдох хэлтэс, агентлаг, байгууллагуудын хяналтад авахуулж, ЗДТГ-ын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хариуцсан мэргэжилтэн нарт үүрэг даалгавар өгч ажиллажээ.

Аймгийн ЗДТГ-аас эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн явцыг 2018 оны 9 дүгээр сарын 25-ны байдлаар гаргуулж, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн үнэлгээ хийж, үндсэн чиглэлийн биелэлтийг гаргаж ажилласан байна.

Санхүү төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ.Үүнд:

-Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймаг, сумын нийт 124 байгууллагын 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхээр тусгаж, хэрэгжүүлж байгаа ба хяналт шалгалтын явц 85 хувьтай байна.

2017 онд хяналт, шалгалтад хамрагдсан төсвийн байгууллагуудад 148.6 сая төгрөгийн 123 төлбөрийн акт, 104,6 сая төгрөгийн зөрчил арилгуулах 9 албан шаардлага өгч байсан бол 2018 оны эхний 10 сарын байдлаар 59.9 сая төгрөгийн 129 төлбөрийн акт, 32.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах 6 албан шаардлага өгсөн байна.

Үүнээс үзэхэд аймгийн ЗДТГ-аас аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийг биелэлтийг гаргаж, хэрэгжилтийн явцыг хянаж байгаа болон ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын харьяа хэлтэс, газруудаас тавих хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлсэн байна гэж үзлээ.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, гүйцэтгэлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

**Бүлэг 1. Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүй байна.**

1. Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг нэмэгдүүлэх зарим нөөц боломжийг зөв тооцоогүй байна.

2. Аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг төлөвлөхдөө орон тооны хязгаарыг баримтлаагүй, 129,5 орон тоог илүү баталж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бодитой тооцоогүй байна.

3. Аймгийн 2018 оны нэгдсэн төсвийн алдагдал 16407,9 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

**Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн эхний 9 сарын орлогын төлөвлөгөө 1171,8 сая төгрөгөөр тасарсан байна.**

1. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр орон нутгийн суурь орлогын төлөвлөгөө 108,7 хувиар биелэгдэх боломжтой байна.
2. Төсөвт болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудаас төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж байхгүй байна.

**Бүлэг 3. Орон нутгийн төсөвт байгууллагууд нийтдээ 2358,4 сая төгрөгийн өртэй гарах төлөвтэй байна.**

1. Орон нутгийн төсөвт байгууллагууд 2018 оны эцэст хүлээгдэж буй гүйцэтгэлээр батлагдсан төсвөөс 2358,4 сая төгрөгийн илүү зарлага гаргаж, өр үүсгэх болзошгүй байна.
2. 3 дугаар улирлын дүнгээр ОНХ сан, ОНХО-ын 15 төсөл арга хэмжээний тендер зарлагдаагүй байна.

**Бүлэг 4. ТЕЗ-ийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохих журмаар тайлагнаагүй байна.**

1. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг зохих журмаар гаргасан байна.
2. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг зохих журмын дагуу дүгнэж тайлагнаагүй байна.
3. Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоодын зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.

**Зөвлөмж**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох албан тушаалтанд зөвлөмж өгөгдөөгүй байгаа болно.

**Аймгийн ЗДТГ-ын дарга Х.Тилегенд:**

1. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн зорилтод түвшингийн биелэлтийг журмын дагуу гаргаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллах, хяналт үнэлгээ хийлгэх

**Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Х.Ерболд:**

1. Орон нутгийн суурь орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэж бодитой төлөвлөх

**Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн санал:**

**ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

**ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

**ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

М.АЙНУР

АУДИТОР

Х.ЕРКЕБУЛАН

АУДИТОР

У.ЕРБОЛ